

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

**2007 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр**

Дугаар 207

**Улаанбаатар
хот**

Үнэт цаас тусгаарлах, үнэт цаасны хадгаламж
дахь дансны гүйлгээг түр зогсоох тухай
журам батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1. “Үнэт цаас тусгаарлах, үнэт цаасны хадгаламж дахь дансны гүйлгээг түр зогсоох тухай журам”-ыг хавсралтаар баталж 2008 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Журам батлагдсантай холбогдуулан энэхүү журам батлагдахаас өмнө “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь хадгаламжид тусгаарлагдсан байгаа үнэт цаасны арилжааг сэргээх эсэх асуудлыг ажлын 14 хоногийн дотор хянан шийдвэрлэхийг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ҮНЭТ ЦААС ТУСГААРЛАХ, ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖ ДАХЬ ДАНСНЫ ГҮЙЛГЭЭГ ТҮР ЗОГСООХ ТУХАЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь үнэт цаас тусгаарлах, тусгаарлалтыг цуцлах, төвлөрсөн хадгаламж дахь дансаар хийгдэх гүйлгээг түр зогсоох, гүйлгээг сэргээх, тусгаарлагдсан үнэт цаасны болон дансан дах мөнгөн хөрөнгийн гүйлгээг түр зогсоох ажиллагаанд хяналт тавих, нэгдсэн бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Үнэт цаасыг тусгаарлах, тусгаарлалтыг цуцлах, төвлөрсөн хадгаламж дахь дансаар хийгдэх гүйлгээг түр зогсоох, гүйлгээг сэргээх шийдвэрийг Хорооны улсын байцаагч /цаашид улсын байцаагч гэх/ шийдвэр гаргана.
- 1.3. Шийдвэр нь байцаагчийн албан шаардлага хэлбэртэй байна.
- 1.4. Улсын байцаагч энэхүү журмын 1.2-т заасан шийдвэр гаргахдаа өөрийн харьяалах дээд шатны улсын ахлах байцаагчид танилцуулж зөвшөөрөл авсан байна.
- 1.5. Энэхүү журмын 1.2-т заасан шийдвэрийн хувийг холбогдох өмчлөгчийн үндсэн брокер, дилерийн компанид хүргүүлэх ба харьяалах брокер, дилерийн компани өөрийн үндсэн харилцагчид шуурхай мэдэгдэх үүрэгтэй.
- 1.6. Улсын байцаагч үндэслэлгүйгээр энэхүү журмын 1.2-т заасан шийдвэр гаргахыг хориглоно.

Хоёр. Үнэт цаас тусгаарлах, тусгаарлалтыг цуцлах, дансны гүйлгээг түр зогсоох, сэргээх

- 2.1. Үнэт цаасыг тусгаарлах нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, тогтоомжид өөрөөр заагаагүй бол тухайн үнэт цаасыг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалахаас бусад эрхийг хязгаарлахгүй.
- 2.2. Үнэт цаасыг зөвхөн дараахь үндэслэлээр улсын байцаагч тусгаарлах ба шаардлагатай гэж үзвэл хадгаламж дахь дансаар хийгдэх гүйлгээг түр зогсооно:
 - 2.2.1. Компанийн нийтэд санал болгон гаргасан хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг худалдан авсан этгээд уг үнэт цаасыг худалдан авснаас хойш ажлын 10 хоногийн дотор Хороонд мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;
 - 2.2.2. Компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээд нь бусад хувь нийлүүлэгчдийн эзэмшиж байгаа хувьцааг худалдан авахаар санал болгох үүргээ биелүүлээгүй;
 - 2.2.3. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах үүднээс тухайн үнэт цаасны арилжааг зөрчилтэй байх үндэслэлтэй буюу арилжаанд оролцогч талын үнэт цаастай холбоотой гаргасан гомдол, хүсэлтийг үндэстэй гэж үзсэн, хянан шалгах ажиллагаа

явагдах хугацаанд уг үнэт цаасыг бусдад арилжих замаар шийдвэр биелүүлэх ажиллагаанд хүндрэл гарч болзошгүй гэж үзсэн;

2.2.4. Шүүхийн шийдвэрээр;

2.2.5. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзсэн буюу зөрчсөн нь тогтоогдсон бусад үндэслэл.

2.3. Үнэт цаасыг тусгаарлах болон хадгаламж дахь дансаар хийгдэх гүйлгээг түр зогсооход байцаагчийн албан шаардлагад дараах зүйлсийг тусгасан байна:

2.3.1. Үнэт цаас тусгаарлах, эсхүл хадгаламж дахь дансаар хийгдэх гүйлгээг түр зогсоох болсон үндэслэл;

2.3.2. Гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тусгаарлах буюу дансаар хийгдэх гүйлгээг түр зогсоох бол гомдол гаргасан хүний эцгийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, гомдлын агуулга;

2.3.3. Тусгаарлах үнэт цаасны нэр, тоо ширхэг;

2.3.4. Тусгаарлах үнэт цаасны байршиж буй дансны эзэмшигчийн нэр, дансны дугаар;

2.3.5. Гүйлгээг түр зогсоох бол дансны дугаар;

2.3.6. Хугацаа зааж үнэт цаас тусгаарлах буюу дансны гүйлгээг түр зогсоох бол үнэт цаас тусгаарлах буюу дансны гүйлгээг түр зогсоох хугацаа;

2.3.7. Шийдвэр гаргасан улсын байцаагчийн нэр, тэмдэг.

2.4. Үндсэн дансны гүйлгээг түр зогсооход тухайн данс дахь холболтын бүх дансаар хийх гүйлгээг давхар зогсооно.

2.5. Тухайлан аль нэг холболтын дансны гүйлгээг нь түр зогсоохоор шийдвэрлэсэн бол энэ нь үндсэн данс болон бусад холболтын дансанд хамаарахгүй.

2.6. Үнэт цаас тусгаарлах болон хадгаламж дахь дансаар хийгдэх гүйлгээг түр зогсоох болсон шалтгаан, нөхцөл арилсан тохиолдолд тухайн шийдвэрийг гаргасан улсын байцаагч буюу улсын ахлах байцаагч, эсхүл ерөнхий байцаагчийн шийдвэрээр үнэт цаасны тусгаарлалтыг цуцлах буюу хадгаламж дахь дансаар хийгдэх гүйлгээг сэргээнэ.

2.7. Үнэт цаасны тусгаарлалт цуцлах, хадгаламж дахь дансаар хийгдэх гүйлгээг сэргээх шийдвэрт дараах зүйлсийг тусгасан байна:

2.7.1. Үнэт цаасны тусгаарлалт цуцлах, эсхүл хадгаламж дахь дансаар хийгдэх гүйлгээг сэргээх болсон үндэслэл;

2.7.2. Тусгаарлалтыг цуцлах үнэт цаасны нэр, тоо ширхэг;

2.7.3. Тусгаарлалтыг цуцлах бол үнэт цаасны байршиж буй дансны эзэмшигчийн нэр, дансны дугаар;

2.7.4. Дансны гүйлгээг сэргээх бол тухайн дансны дугаар;

2.7.5. Шийдвэр гаргасан улсын байцаагчийн нэр, тэмдэг.

2.8. Хугацаа зааж үнэт цаас тусгаарласан буюу дансны гүйлгээг түр зогсоосон бөгөөд уг хугацаа дуусгавар болсон, хугацааг үргэлжлүүлэн сунгах тухай улсын байцаагчийн шийдвэр дахин ирээгүй тохиолдолд үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага бие даан тусгаарлалт цуцлах буюу дансны гүйлгээ сэргээж энэ талаар Хороонд мэдэгдэнэ.

Гурав. тусгаарлагдсан үнэт цаас, гүйлгээг түр зогсоосон дансны бүртгэл хөтлөх, хяналт тавих

3.1. Үнэт цаасны газар нь тусгаарлагдсан үнэт цаас, гүйлгээг түр зогсоосон дансны бүртгэл хөтлөх, хяналт тавих мэргэжилтэнтэй байх бөгөөд тус мэргэжилтэн нь /цаашид бүртгэл хөтлөх мэргэжилтэн гэх/ улсын байцаагчийн шийдвэрийн бүрдэл бүрэн эсэх, үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага шийдвэрийг биелүүлсэн эсэх, үнэт цаас эзэмшигчид мэдэгдсэн эсэх, үнэт цаас тусгаарласан болон дансны гүйлгээг түр зогсоосон шалтгаан, нөхцөл арилсан тохиолдолд холбогдох шийдвэрийг хариуцсан байцаагч цаг тухайд нь гаргаж байгаа эсэхэд байнгын хяналт тавьж ажиллана.

3.2. Журмын 3.1-д заасан бүртгэлд үнэт цаас тусгаарласан болон дансны гүйлгээг түр зогсоосон байцаагчийн албан шаардлагын огноо, дугаар, үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага шийдвэрийг биелүүлсэн огноо, тус байгууллагаас шийдвэрийг биелүүлсэн талаар ирүүлсэн албан бичгийн огноо, дугаар, үнэт цаасыг тусгаарлах болон дансны гүйлгээг түр зогсоох болсон шалтгаан, нөхцөл, өргөдөл, гомдлын дагуу үйлдэгдсэн бол тухайн гомдлын агуулга, гомдлын Ажлын албаны бичиг хэрэгт бүртгэсэн бүртгэл, хяналтын картын дугаар, үнэт цаас эзэмшигчид мэдэгдсэн тухай тэмдэглэл /хэрэв мэдэгдэх боломжгүй байсан бол шалтгаан/, үнэт цаас тусгаарласан болон дансны гүйлгээг түр зогсоосон шалтгаан нөхцөл арилсан талаарх мэдээлэл, тусгаарлалтыг цуцалсан болон дансны гүйлгээг сэргээсэн байцаагчийн албан шаардлагын огноо, дугаар, хугацаа зааж үнэт цаас тусгаарласан буюу дансны гүйлгээг түр зогсоосон бол тухайн хугацаа өнгөрсний дараа үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага энэхүү журмын 2.8 дахь заалтыг хэрэгжүүлсэн эсэхийг тусгасан байна.

3.3. Улсын байцаагч нь үнэт цаас тусгаарлах, дансны гүйлгээг түр зогсоох шийдвэр гаргасан өдрөө энэ талаар бүртгэл хөтлөх мэргэжилтэнд мэдэгдэж, байцаагчийн албан шаардлагыг хүлээлгэн өгөх ба бүртгэл хөтлөх мэргэжилтэн нь холбогдох бүртгэлийг хийн, албан шаардлагыг Ажлын албаны бичиг хэрэгт шилжүүлэн өгөх буюу үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад хүргэх ажиллагааг зохион байгуулна.

3.4. Тусгаарлагдсан үнэт цаасны арилжааг 30 хоногийн дотор сэргээгээгүй тохиолдолд бүртгэл хөтлөх мэргэжилтэн нь энэ талаар холбогдох хариуцсан мэргэжилтнээс тодруулан, тухай бүр бүртгэлд тэмдэглэх бөгөөд энэхүү ажиллагааг тухайн үнэт цаасны арилжааг сэргээх, эсхүл эрх бүхий байгууллагаас шийдвэр гарах хүртэл явуулна.

3.5. Бүртгэл хөтлөх мэргэжилтэн нь улирал бүр, тухайн улирлын эхний 10 хоногт багтаан дээд шатны улсын байцаагч болон өөрийн харьяалах нэгжийн удирдлагад бичгээр тайлагнана. Шаардлагатай гэж үзвэл үнэт цаас тусгаарлах, гүйлгээг түр зогсоох ажиллагаатай холбоотой мэдээллийг Ажлын албаны дарга болон Хорооны даргад танилцуулна.

Дөрөв. Бусад

4.1. Үндэслэлгүйгээр үнэт цаас тусгаарласан, дансны гүйлгээг түр зогсоосон нь тогтоогдвол улсын байцаагчийн шийдвэрийг түүний дээд шатны улсын байцаагч хүчингүй болгож, үнэт цаасны тусгаарлалтыг цуцалж, гүйлгээг сэргээх шийдвэр гаргана.

4.2. Улсын байцаагчийн үнэт цаас тусгаарлах, дансны гүйлгээг түр зогсоох, тусгаарлалтыг цуцлах, гүйлгээг сэргээхтэй холбоотой ажиллагааны талаарх гомдлыг түүний дээд шатны улсын байцаагчид гаргана.

4.3. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---